

## АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

2021 оны байгууллагын гүйцэтгэлийн жилийн төлөвлөгөөнд нийт 8 зорилго 17 зорилтын хүрээнд 88 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

1. Арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг хийх, үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох зорилтын хүрээнд 4 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 3 арга хэмжээний хэрэгжилт 100 хувь, 1 арга хэмжээний хэрэгжилт 50 хувь, дунджаар 87.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус зорилтын хүрээнд арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийг 2000 хүнд хийхээр төлөвлөсөн хэдий ч коронавирусын цар тахалтай холбоотой урьдчилан сэргийлэх үзлэг хийгдээгүй бөгөөд ЭМЯ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу Ковид-19 дархлаажуулалтын цэгийг байгуулж иргэдэд тусламж үйлчилгээг үзүүлсэн.
2. Халдварт болон халдварт бус өвчний, урьдчилан сэргийлэлт, тандалт, хяналтын тогтолцоог сайжруулах зорилтын хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 100 хувь байна.
3. Арьс харшил, эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах зорилтын хүрээнд 8 ажил төлөвлөснөөс 5 ажил 100 хувь, 1 ажил 70 хувь, 2 ажил 50 хувь буюу дунджаар 83.75 хувийн гүйцэтгэлтэй байна. Лабораторийн оношилгоо шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн ч цар тахлын улмаас коагулограмм аппарат тоног төхөөрөмжийн тээвэрлэлт хил гааль дээр саатаж захиалгын нийлүүлэлт хойшлогдсон. Коронавирусын цар тахлын улмаас амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг, өдрийн эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо багассан зэрэг шалтгааны улмаас жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл буурсан. ЭМЯ-наас эмнэлгийн зориулалтын тоноглогдсон автомашинтай болох ажлыг төлөвлөсөн нь 2022 онд шийдэхээр хойшлогдоод байна.
4. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоо, арга хэрэгслийг сайжруулан, тасралтгүй байдлыг хангах зорилтын хүрээнд 12 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

5. Эм зүйн үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг ханган, зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилтын хүрээнд 4 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 100 хувь байна.
6. Эмнэлгийн халдвар, хамгаалал, аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд 11 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй байна.
7. Арьс харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх зорилтын хүрээнд 3 ажил төлөвлөж 100 хувь гүйцэтгэсэн.
8. Арьс харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр чадварлаг хүний нөөцөөр хангах зорилтын хүрээнд 7 арга хэмжээг төлөвлөснөөс 100 хувийн хэрэгжилттэй байна.
9. Гүйцэтгэлийн удирдлагын оновчтой тогтолцоог хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 3 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөж 100 хувь гүйцэтгэсэн.
10. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцааны соёл, хариуцлагыг дээшлүүлэх зорилтын хүрээнд 3 арга хэмжээг төлөвлөж 100 хувь хэрэгжүүлж ажилласан.
11. Хүний нөөцийн нийгмийн баталгааг сайжруулах зорилтын хүрээнд 5 ажил төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.
12. Эдийн засгийн үр ашгийн тооцоолол хийж, санхүүгийн тогтолцоог оновчтой болгох зорилтын хүрээнд 6 ажил төлөвлөж 100 хувь хэрэгжүүлж ажиллалаа.
13. Хүн амын арьсны эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд суурилсан дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд 3 ажлыг төлөвлөж 100 хувь хэрэгжүүлсэн.
14. Цахим технологийг бүрэн нэвтрүүлэх зорилтын хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 100 хувийн гүйцэтгэлтэй байна.
15. Хагас бие даасан засаглалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд 3 ажил төлөвлөж 100 хувь гүйцэтгэж ажиллалаа.
16. Хэрэглэгч төвтэй, сэтгэлд шингэсэн, үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд төлөвлөсөн 4 арга хэмжээний хэрэгжилт 100 хувь байна.
17. Төр хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлэн, гадаад харилцааг хөгжүүлэх зорилтын хүрээнд 6 ажлыг төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй байна.